

## ЖИЖИГ ОРНУУДЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН АСУУДАЛ

Чарлес Салмон\*

Энэ удаагийн миний лекцийн үндсэн сэдэв бол жижиг орнуудын аюулгүй байдал, гадаад бодлогын асуудлууд, түүний учир холбогдлын тухай юм. Юуны өмнө жижиг орнуудын бүрэн эрхт байдлын үзэл баримтлалын тухай хэдэн үг хэлье. Ер нь жижиг орнууд бүрэн эрхт байдлаа хамгаалах чиглэлээр яаж ажиллах талаар тодорхой ойлголттой байх нь маргаангүй чухал. Түүнчлэн жижиг орон гэдгийг яаж тодорхойлох, түүний хөгжил, аюулгүй байдлын хэрэгцээ шаардлагын талаар нарийвчлан ярилцах болно. Мөн жижиг орнуудын аюулгүй байдалд заналхийлж болох хүчин зүйлсийг хэрхэн тооцох, тэд аюулгүй байдлаа хангахдаа олон талын сонголт хийх эрх, боломж нөхцөл, хөгжлийн асуудлуудаа судлах зэрэг олон хүчин зүйлсийн талаар хэлэлцүүлэг маргаан явуулахдаа зарим практик амьдралын жишээ болон өөрийн энэ талын туршлагадаа түшиглэх болно. Өнөөгийн глобалчлалын эриний өмнө ч гэсэн жижиг орнуудад зохих хэмжээний давуу тал байсан болохыг төгсгөлд нь хэлэх нь зүйтэй болов уу. Одоо эхлээд бүрэн эрхт байдлын тухай бага зэрэг ярья. Та бүхэн мэдэж байгаа. Юу вэ гэвэл улсын тухай, түүний байр байдал, дүр төрхийг тодорхойлоход маш чухал, ойлголт өгдөг хүчин зүйл, нэр томъёоны нэг нь бүрэн эрхт байдал юм. Бүрэн эрхт байдал гэдэг нэр томъёонд сүүлийн зуун жил тэр дундаа гарцаагүй, дэлхийн II дайнаас хойш онцгой чухал ач холбогдолтой тод томруун хувьсал өөрчлөлт гарсныг бид харлаа. Дотоод гадаад хэрэг явдлын хоорондох саад тотгор хэмээн нэрлэгдэж байсан зүйлс улирч өөрчлөгдөн шинэчлэгдсээр байна. Нэгэнтээ улсын бүрэн эрхт

\* Чарлес Салмон Хавайн Хонолулу дахь Ази, Номхон далайн аюулгүй байдлын судалгааны төвийн гадаад бодлогын зөвлөх, аюулгүй байдлын коллежийн факультетийн гишүүн, Элчин сайд цол хэргэмтэй. Аюулгүй байдлын судалгааны төв 1995 онд АНУ-ын Батлан хамгаалах яамны харъяанд байгуулагдсан. Чарлес Салмон Азийн нэлээд оронд дипломат болон цэргийн салбарт өндөр алба хашиж, улс орны аюулгүй байдал, гадаад бодлогын асуудлаар дагнан мэргэшжээ.

Тэрбээр Монголд элэгтэй америкчуудын нэг бөгөөд Монголын дипломатуудтай 1989 оноос ойр дөт танилцаж, тэр цагаас хойш манай улсыг анхааран сонирхож, гадаад бодлого, аюулгүй байдлыг хангах салбарын ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх, Монгол улсыг энэ чиглэлийн Бүсийн байгууллагад гишүүнээр элсүүлэх зэрэгт бодитой хувь нэмэр оруулсан хүн юм.

Чарлес Салмон манай улсад хоёрдахь удаагаа 1999 оны дөрөвдүгээр сарын дундуур айлчлах үеэрээ Гадаад харилцааны яаманд уригдан уншсан энэхүү лекцийг бага зэрэг товчлон нийтлэв. Тус сэтгүүлд нийтлэх зөвшөөрөл олгож туслалцаа үзүүлсэн АНУ-ын Элчин сайдын яамны хэвлэл, мэдээллийн албаныханд талархлаа илэрхийлье.

байдлын эрх нь ердөө л бие даасан аль нэг улсын онцгой эрхээр хязгаарлагддаг байсан бол эдүгээ олон улсын харилцан итгэлцлийн дор нэгдмэл цогц хэлбэрээр илэрхийлэгдэн НҮБ-ын дүрэмд тусгалаа олжээ. Улсын бүрэн эрхт байдал гэдэг ойлголт янз бүр. Жишээ нь ямар нэг улс эрх ашгаа хамгаалан дайн зарлалаа гэхэд бүрэн эрхт байдлын эрхийн чухал үндсэн гол уламжлалын нэг улсын эрх зөрчигддөг. Гэхдээ улсуудын бүрэн эрхт байдлын эрхийн үндсэн шаардлага нь хууль зүйн дагуу явагддаг гэхэд хэцүү. Улс орнууд хууль эрхийн актуудыг илэрхий өөрийн үзэмжээр гуйвуулан түүнийгээ ашиглан гадагш дайн хийдэг. Ингэснээр бүрэн эрхт байдлын маш чухал, уламжлалт суурь эрх орхигддог. Гэвч тэд дэлхий нийтийн зэмлэл, шийтгэлээс зайлсхийж, буруу үйлдлээ зөвтгөж чадахгүй. НҮБ-ыг үүсгэн санаачлагчид хүний эрхийн түгээмэл тунхаглалыг НҮБ-ын дүрмийн нэмэлт болгон зохиосон билээ. Энэ тунхаглалын заалтууд он жил өнгөрөх тутам улам олон зүйлд хамаарагдах болсон. Жишээлбэл, эмэгтэйчүүдийн болон хүүхдийн эрх түүнчлэн нийгэм улс төрд ч маш чухал нөлөө үзүүлсэн төдийгүй өөр бусад олон олон зүйлс үүнд хамаарагдах болов. Энэ бүхэн нь улсуудын дур дураараа аашилдаг хэмжээгүй эрх дархад хязгаар тавьж чадсан. Товчхон хэлэхэд гучин жилийн дайныг 1648 онд төгсгөл болгож, хөгжиж байгаа улс үндэстний бүрэн эрхт байдлын тухай нэр томъёоны нэг чухал зүйл болсон Вестфаллийн гэрээнээс хойш бид маш урт зам туулж ирлээ. Өнөөгийн глобалчлал нь бүрэн эрхт байдлыг огт өөр талаас харахад хүргэн өөр үзэгдлийг төрүүлэх байх. Жижиг улс гэдэг ойлголтонд хамгийн их ач холбогдол өгөхүйц онцгой нэг хүчин зүйл нь тухайн улсын нөөц боломж туйлын ховор хомс, хязгаарлагдмал явдал зүй ёсоор орно. Энэ хүчин зүйл нь тухайн улсын олон улсын тавцанд эзлэх байр суурь, нэр хүнд, эрх мэдэл хэр зэрэг байхад гарцаагүй нөлөөлдөг. Нөөцийн хязгаарлагдмал байдал нь тухайн улсын аюулгүй байдал болон эдийн засгийн бодлогод мөн нэгэн адил нөлөөлнө. Жижиг улсын Засгийн газрууд хөрөнгө нөөц баялгаа тодорхойлж, онцгой шинж чанартай нөөцүүдийг ашиглахдаа маш хянуур болгоомжтой хандан өөрийн илүү давуу талдаа түшиглэн шилэн сонголт хийж, хөгжлийн стратегээ тодорхойлох ёстой. Энэ нь газар нутгийн тодорхой байршил, түүхэн харилцаануудыг өөртөө агуулна. Одоо жижиг орныг хэрхэн тодорхойлдог тухай бага зэрэг өгүүлье.

Жижиг болон жижгэвтэр орнуудын хэтийн төлөв янз бүр гэж би бодно. Олонхи улс үндэстэн жижиг гэдэг ойлголтонд хамрагдана. Дэлхийн Банкны атласт тодорхойлсноор мөн чанартаа 209 орон 5 тэрбум хүн ам дээрх ойлголтонд хамрагддаг аж. Эдгээр орноос 55 орон саяас бага хүн амтай, 45 орон 1-5 сая хүн амтай, энэ ангилалд Монгол Улс орох нь мэдээж. Мөн 10 орон 5-6 сая хүн амтай аж. Дээрхи байдлаас үзвэл нийт улсын дөрөвний нэг нь саяас бага хүн амтай, бараг тэн хагас орчим улсын хүн ам 6 саяас бага бөгөөд үүнд хамрагдах орны тоо ч нэмэгдсээр байна. Жишээлбэл, Чехословак Пакистан, Бангладеш гэх мэт.



Сүүлийн үед олон эрдэмтэд жижиг орон гэдэгт ямар орнуудыг хамруулж ойлгох талаар бүрэн гүйцэд тодорхойлолт гаргахад анхаарлаа хандуулж ирлээ. Заримдаа тэдний аль нь ч гэсэн сая ба түүнээс бага хүн амтай орныг буурай хөгжилтэй, жижиг орон гэдэг ангилалд оруулахын тулд маш дур зоргоороо хандаж үнэхээр хэцүү, ярвигтай олон үл мэдэгчтэй тэгштгэл гаргаж ирсэн. Үнэндээ хуульч хүний хувьд би тийм, толгой эргүүлсэн, олон үл мэдэгчтэй тэгштгэл болж хувирахуйц ярвигтай тодорхойлолт шаардлагагүй болов уу гэж үзнэ. Энэ бол миний ердийн ойлголт. Нийтийн ойлголт ч ийм байгаа гэдэгт би найдаж байна. Эцсийн бүлэгт тухайн улс жижиг улс мөн үү? биш үү? гэдэг нь тэр улс өөрийгээ хэрхэн ойлгож, мэдэрч байгаагаас ихээхэн хамаарна. Түүнчлэн хөрш орнууд нь хэрхэн хүлээн авч яаж хандаж байгаа зэрэгтэй маш их уялдаа холбоотой асуудал юм. Канад жижиг улс биш гэдэг нь гарцаагүй үнэн, хэнд ч ойлгомжтой. Гэхдээ хөрш АНУ-тай харьцуулбал магадгүй жижиг улсын шинж онцлогтой байж болох юм.

Одоо эрдэмтэн, судлаачид бүтээл туурвилдаа жижиг орны тухай хэрхэн юу гэж бичиж байгаа талаар бага зэрэг лавшруулан ярья. Ер нь жижиг орны талаар тусгайлан гарсан судалгааны ном бүтээл харьцангуй цөөн. АНУ дахь реалистик сургуулийн талыг баримтлагч Чикагогийн их сургуулийн Ханс Моргантаугийн Олон улсын харилцааны онолд жижиг үндэстний талаар тусгайлан хэлсэн юм бараг алга. Ханс Моргантау хүчтэй, хүчирхэг гүрнүүдийг сонирхдог байсан бөгөөд семинарын ном нь ч 1948 онд гарсан билээ. Тэр үед бидэнд жижиг орны талаар хангалттай мэдэх зүйл алга байлаа. Дэлхийн II дайны дараа шинэ шинэ улсууд гарч ирж тэдний талаар бичиж туурвих сонирхлыг судлаачдын дунд төрүүлсэн билээ. Үүнд НҮБ-аас эрхлэн гаргасан ном бүтээлүүд ч орно. Хүйтэн дайны үед жижиг орнууд сөргөлдөгч талуудын ашиглах хэрэгсэл, тэрхүү хүйтэн дайны золиос болж байлаа. Яагаад гэвэл тэдний эрх нь гадаад байдал дээрээ бодитойгоор илэрч харагддаггүй, тэдний тэмцэл, бодит хүчин чармайлт нь их гүрнүүд болон хэт их гүрнүүдийн зөрчил мөргөлдөөн эсэргүүцэлтэй тулгардаг байлаа. Хүйтэн дайны дараах үе бол жижиг орнуудын хувьд маш их сонирхолтой, тэмдэглүүштэй олон өнгө аястай болж ирлээ. Үүнийг ч Монгол улс маш сайн мэдэж байгаа. Жижиг улсуудын анхаарал сонирхлыг маш их татаж байгаа зүйлийн нэг бол нийтлэг бодит шалтгаан, нөхцөлүүдийг агуулсан өөрсдийнхээ эрх мэдлийг өсгөн нэмэгдүүлэх асуудал юм. Мөн түүнчлэн тэдний энэ асуудал Дэлхийн Шинэ дэг журам гэдэгтэй салшгүй холбогдоно. Шулуухан хэлэхэд энэ Дэлхийн Шинэ дэг журам гээч маань ихээхэн учир дутагдалтай гэж би үздэг.

За одоо жижиг улсуудын аюулгүй байдлын тухай зарим нэг судлаачид юу гэж үзэж байгаа талаархи яриандаа эргэж оръё. Энд би зарим талаар шинэвтэр гэж болохоор 80-аад оны дунд үеийн нэгэн судлаачийн бүтээлийн тухай өгүүлэх гэсэн юм. Профессор Майкл Хандел



“Олон улсын систем дэх жижиг орнууд” гэдэг бүтээлдээ маш чухал хэрэгтэй гол санаануудыг гаргаж тавьсан бөгөөд жижиг буурай гэдэг үгийг харилцан орлуулж хэрэглэсэн.

Жижиг орнууд хязгаарлагдмал эрх чөлөөгөө хэм хэмжээнд нь хамгаалж тэсч үлдэх чиглэлээр арга мэх хайж, маневр хийж улс орныхоо бүрэн бүтэн байдлыг урт удаан хугацаанд хадгалахын тулд тэдний сэтгэл хамтадаа түгшиж байдаг гэж Майкл Ханделийн нотолсон нь үнэн бодитой зүйл гэж би боддог.

Хандел тухайн орон бүхэлдээ буурай жижиг юм уу эсвэл бүхэлдээ хүчтэй юм уу гэдэг нь асуудлыг тийм ч гол үндсэн нөхцөл шалтгаан болдоггүй гэсэн байдаг. Миний эх орон АНУ, Вьетнамын дайнд ялаагүй ч бид үүнийгээ хүлээн зөвшөөрсөн дүр үзүүлээ ч үгүй. Энэ нь Фидель Кастро засгийн эрхэнд гарснаар Кубын гадаад бодлогод хүчтэй нөлөө үзүүлэх болсонтой агаар нэг юм. Түүнчлэн хуучнаар Зөвлөлт Холбоот Улс буурай хөгжилтэй орнууд тухайлбал, тухайн үедээ харьцангуй сул дорой Албани, Югослав, Румын зэрэг орнуудын зүгээс үзүүлж байсан олон удаагийн өдөөн хатгалгыг тэвчин тэсч өнгөрүүлж байсан билээ. Энэ нь дээрх орнуудын цаад талд нь асар олон далд хүчнүүдийн нэгдсэн зорилготой бодлого байсныг тайлбарлах хэрэггүй бизээ. Тэгээд ч жижиг буюу буурай хөгжилтэй орон бүр бүхэлдээ сул дорой биш шүү дээ. Тэдэнд ч гэсэн хүч чадлын маш чухал дотоод эх булаг, давуу тал, нөөцүүд бий. Тэд ч өөрсдийнхээ энэ давуу тал нөөц боломжоо ашиглаж сурчээ. Мөн түүнчлэн их гүрнүүд хүч чадлаа бэхжүүлэхийн төлөө улс орныхоо чадварлаг удирддаг удирдлагын нарийн арга ухаанаас ч жижиг орнууд бас суралцаж байна. Энэ бүхэн нь жижиг орнууд өөрсдийнхээ ашиг сонирхол, хүч чадлыг бэхжүүлэх гадаад эх үүсвэртэй болж байна гэсэн үг. Миний үзэж буйгаар улсын хүчин чадал нь тэргүүн зэргийн ач холбогдолтой үнэт зүйлс хөндөгдсөн тохиолдолд сөрөг арга хэмжээ авдаг зайлшгүй хэрэгсэл болсон хэвээр байна. Гэвч энэ нь хүч чадлаа өөр бусад улс орны эсрэг сөрөн зогсох хэрэгсэл болго гэсэн хэрэг биш нь ойлгомжтой. Америкийн нэртэй улс төрийн тайлбарлагч Вольтер Липман бичихдээ: “Улс үндэстний аюулгүй байдлын хэм хэмжээ гэдэг нь тухайн улс үндэстэнд ямарваа аюул занал байхгүй байх, дайнаас сэрэмжлэн түүнээс зайлсхийх, хэрэв нөгөө тал дайныг уриалан дуудвал дайныг ялалтад хүргэхэд түүний гол ач холбогдол оршино” гэжээ. Энэ бүхнээс үзэхэд тухайн улсын тэргүүн зэргийн ач холбогдол өгч үнэлэн цэгнэж байдаг хамгийн чухал үнэт зүйл бол улсын хүчин чадал болох нь тодорхой байна.

Монголын Үндэсний аюулгүй байдлын талаархи баримт бичиг, үзэл баримтлалыг уншаад төрсөн сэтгэгдлээ та бүхэнтэй хуваалцахад: Танай энэхүү аюулгүй байдлын үзэл баримтлалд Вольтер Липманы дээр өгүүлсэн санааг маш нарийн нягт, ойлгомжтой тодорхойлжээ.

Одоо би буурай хөгжилтэй болон жижиг орнуудын аюулгүй байдалд нөлөөлөхүйц зарим аюул заналын талаар та бүхэнтэй санал солилцох



гэсэн юм. Болзошгүй аюул занал нь тодорхой зохион байгуулалттай иж бүрдэл хэсгүүдээс бүрдэнэ гэж би бодно. Үүнд мэдээжээр газар нутгийн, улс төрийн, эдийн засгийн, соёлын, үзэл суртлын, технологийн аюулгүй байдлууд гэсэн категоруудаас бүрдэх нь илэрхий. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд болзошгүй аюул заналын нарийн ширийн зүйлс, учирч болзошгүй аюул заналын дохио санамж, нөхцөл байдал зэргийг бүрэн хамруулж, маш нарийн тодорхойлжээ гэдгийг дээрхтэй холбогдуулан энд дахин заан тэмдэглэмээр байна.

Болзошгүй аюул заналын эхний жишээ гэвэл газар нутгийн түрэмгийлэл. Одоогийн Африкийн энэ талын асуудалд бид харамсаар байгаа юм. Тухайлбал, Этиоп, Эритрейн хооронд болж буй тулалдаан байна. Шуудхан хэлэхэд газар нутгийн хэсгийг өмчлөхдөө иймэрхүү байдлаар хандах нь тийм ч чухал хүсүүштэй эд биш. Нутаг дэвсгэрийн талаархи иймэрхүү олон маргаан зөрчил Америк тивд бага хэмжээгээр, мөн түүнчлэн ертөнцийн хаа нэгтээ үлдэж хоцорсон нь түүхийн явцад хуучин колонийн хил хязгаарууд болон ер нь хил тогтоолтыг муу зурагласантай холбоотой гэж би бодож байна.

Үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болох зарим нэг уламжлалт биш аюул заналын нэг төрөл бол хууль бус цагаачдын асуудал юм. Миний бие 1983-1985 онуудад Мияньмар буюу Бирмд ажиллаж байх үед яригдаж байсан хууль бус цагаачдын асуудал өнөө хэр тэнд хүнд хэвээр байна. Уламжлалт биш аюул заналын бас нэг төрөл бол хар тамхи, мансууруулах бодис юм. Хаана нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал ноцтой болж эхэлнэ, тэнд хар тамхи, мансууруулах бодис эрхлэгч байгууллагуудын хүч чадал хоёр дахин нэмэгддэг. Иймэрхүү асуудал Өмнөд Америкт тухайлбал Колумби мэтийн орнуудад байдгийг бид мэднэ. Өөр бусад орнуудад гарч буй асуудлууд улсын аюулгүй байдалтай нягт холбогдсон бослого, хуйвалдаан зэргээс үүдэлтэй. Өмнөд Филиппинчүүд лалын салан тусгаарлагч хэсэг бүлгүүдийн хагарал, бослогын уршигаар хүнд гарз хохирол, зовлон гамшигт өртсөн хэвээр байна. Мөн түүнчлэн жижиг орнуудын төр бие даасан хараат бус байдлаа баталгаажуулахын тулд болзошгүй гадаад аюул занал, дотоодын хямрал үймээн, эсэргүүцлийг дарах зэрэгт албадлагын болон дипломатын шугамаар нарийн арга хэрэглэх, өөр бусад түнш орнуудаасаа тусламж дэмжлэг авах талын асуудлыг урьдчилан нарийн төлөвлөж тооцсон байдаг. Үүний нэлээд сүүлийн үеийн нэг жишээнд Ази, Номхон далайн бүс нутгийн Папуа болон Шинэ Гвиней улс татагдан ороход хүргэсэн, Бауганвиллид болсон хэрэг явдлыг нэрлэж болох юм. Яагаад гэвэл Бауганвиллийн хуйвалдагчдыг ялан дийлэхийн тулд Европын ашгийн байгууллагын шийдвэрээр тэдэнд 30 сая ам.доллар өгсөн. Энэ нь улсын аюулгүй байдалд эдийн засгийн аюул яаж нүүрлэдэгийг харуулж буй хэрэг бөгөөд мөн хэд хэдэн газар нутгийг хамаарч байна гэсэн үг. Нөгөө талаар асар их өр төлбөрийн хүнд дарамтыг авчирж байгаа юм. Хөгжиж байгаа орнууд асар



их хэмжээний өрийн дарамт, сүйрлээс ангижрах бодит боломж, илүү үр дүнд хүрэх, төлбөрийн чадвартай болох арга зам байна гэж би боддог. АНУ жил гаруйн өмнөөс энэ талаар нэлээд нааштай бодлого баримталж байгаа явдалд би сэтгэл хангалуун байгаа. Хөгжиж байгаа орнуудын өрийн маргааныг хэлэлцэхийг өнөөгийн цаг үе биднээс тулган шаардаж байна.

1988 онд Филиппинд ажиллаж байх үеийн нэгэн тохиолдлыг би санаж байна. Тэр үед Филиппинчүүдтэй тогтоосон манай улсын үндсэн хэлэлцээрийг сунгах гэрээ хэлцэл хийх үеэр Филиппинчүүд эргэж төлөгдөөгүй байгаа зарим өр зээлээ хэрхэн ямар арга хэлбэрээр нөхөн төлөх асуудлыг гэрээнд ямар байдлаар тусгах талаар ихэд сонирхож байлаа. Тухайн үед манай Засгийн газар энэ талаар маш хатуу байр суурь баримталж байсан юм. Одоо АНУ иймэрхүү асуудал шийдэх тал дээр хувьсал өөрчлөлт хийж чадсан гэж би боддог.

Улсын бүрэн эрхт байдал болон аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй аюул заналын нэг төрөл бол байгалийн нөөц баялгийн аюулгүй байдал юм. Ийм болзошгүй аюул заналын хийсвэр жишээг Лаос дээр авч үзье. Хэн нэгэн Лаост хууль бусаар нэвтрэн орж, Лаосын өргөн уудам газар нутгаар нэлдээ тархсан тус улсын байгалийн үндсэн нөөц баялаг болох ой модыг Төв Засгийн газрын зөвшөөрөлгүйгээр ашиглах гэсэн оролдлого байж болох юм.

Үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй аюулын өөр нэг төрөл бол гаднын соёл байж болно. Бид үүнийг соёлын аюул гэдэг. Энд би дахин Лаосаар жишээ авч хэлье. Лаос орон хөрш Тайландтай маш их урт нутаг дэвсгэрээр хиллэдэг. Энэ нь Лаосчууд Тайландын соёлыг ямарч хориг саадгүй тулгалтаар хүлээн авч, үнэн хэрэгтээ тэдний уламжлалт соёл маш хялбархан түрэгдэж байна. Одоо Лаост үндсэндээ Тайландын соёл, радио өргөн нэвтрүүлэг давамгайлах болжээ. Иймэрхүү жишээ Хойт Америкт байдгийг бид мэднэ. Юу гэвэл Америкийн соёл Канадын соёлд хүчтэй нөлөөлж байна. Канадын соёл түүнд уусч байна. Энд дахин тэмдэглэж хэлэхэд Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд соёлын бүрэн бүтэн байдал, түүнийг үнэлэн хүндэтгэх, соёлын түүхээ хамгаалах тал дээр маш тууштай хандаж чухал ач холбогдол өгсөн байна.

Үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй зарим хүчин зүйлүүдийг тоочиж үзвэл энэ нь гол төлөв жижиг орнуудад хадгалагдаж үлдсэн байна. Үүний нэг тод жишээнд НҮБ-д тоо нь өсөн нэмэгдэж буй жижиг орнууд, мөн тиймэрхүү бүсийн байгууллага болох ASEAN, SAARC (Энэтхэгийн Дэд тивийн Аюулгүй байдал, Хамтын Ажиллагааны Байгууллага)-ын гишүүн орнуудыг нэрлэж болох юм.

Монголын хувьд гэвэл ASEAN-ы гишүүн жижиг орнууд шиг хөгжин цэцэглэж олон улсын зүгээс үзэгдэж харагдахуйц тусламж дэмжлэг аван олон улсын тавцанд гарах хэрэгтэй. Энэ нь жижиг орнуудын хувьд маш их ашигтай гэж би үздэг. Нэмж хэлэхэд жижиг орнуудын үйл ажиллагаа,

хүчин зүтгэл, нөхцөл боломж нь НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, холбогдох агентлагуудын сүлжээнд хамрагдсан байдаг. Жижиг орнууд олон улсын тавцан дээр өөрсдийн боломжоо ашиглан тодорхой зорилтыг хэрэгжүүлэх нөхцөлөөр хангагдсан. Тийм учраас цагийн байдлыг тун гярхай ажиглаж харьцангуйгаар маш боломжтой арга хэлбэрээр өөрийн потенциалгаа байн байн илэрхийлэн харуулж байх хэрэгтэй. Жишээ нь Элчин сайд Ла Порта бид хоёр Шинэ Зеландад нэлээд тогтвортой суурин байсан тэр цагт Монголоос хүн амаар цөөн харьцангуй жижиг орон-Шинэ Зеланд олон улсын тавцан дээр лут их нэр нөлөөтэй байсан юм. Шинэ Зеланд тэр үед Далайн хуулиар НҮБ-ын конвенци гаргуулахад маш чухал үүрэг гүйцэтгэснийг би санаж байна.

Одоо би жижиг орнууд эрх чөлөө, тусгаар тогтнолоо сахин хамгаалах арга, хамгаалалтын зарим механизмуудын талаар цухас дурдаад өнгөрөх болно. Жижиг орнууд аюулгүй байдлаа хамгаалах нэг арга бол Дэлхийн шинэ дэг журамд байр сууриа олох явдал юм. Ингэснээр жижиг орнууд бүрэн эрхт байдлаа хамгаалахдаа боломжтой арга хэрэгслэлээр тусламж дэмжлэг олж авч чаддаг болно гэж би хэлэх байна.

Өөр нэг арга зам бол жижиг орныг ивээлдээ авах тийм өмгөөлөн хамгаалагчийг эрж хайж хэрэгтэй. Хамгаалалт нь олон янзын хэлбэр төрх, өнгө аястай байж болно. Тухайлбал, бусад орнуудтай эвсэл холбоо байгуулж болох юм. Ийм эвсэл холбоо харилцааны нэг хэлбэр бол Ази, Номхон далайн бүс нутгийн таван оронтой АНУ-ын тогтоосон холбоо, харилцааг нэрлэж болох байна. Иймэрхүү хамгаалалтын холбоо, харилцаа нь үнэнч шударга байдал, харилцан итгэлцэл дээр тогтдоогоороо давуу талтай. Хамгаалагч нь тухайн орныг батлан хамгаалах талаар анхаарал тавьж, арга хэмжээ авч үнэхээр чаддаг. Тусгайлан хамгаалагдсан орон мөн чанартаа батлан хамгаалах үйл ажиллагаандаа асар их хөрөнгө зардал гаргах шаардлагагүй болно. Гэвч ийм маягийн харилцаа нь нэлээд гарз хохиролтой, эрх чөлөө, тусгаар тогтнолоо хамгаалах арга тактикаа тодорхой хэмжээгээр алдаж болзошгүй. Энэ тохиолдолд хамгаалагч маань илүү онцгой эрх дарх, байр суурь олж авах үндсэн шалтаг шалтгаан болж эсрэгээр эргэж мэдэх юм. Тэгэхгүй гэх баталгаа ямар ч төрлийн холбоо, харилцаанд байхгүй. Энэ бүхэн нь авч үзэж болохуйц хэлэлцэн зөвшилцэх зүйлүүдийн нэг юм. Өнөөгийн нөхцөлд аюулгүй байдалтай бага зэрэг холбоотойгоор хамгаалалтын харилцаа өргөжиж ч магадгүй.

Аюулгүй байдлыг хангах талд тооцож болохуйц эвсэл бол хамгаалалтын холбоо харилцааны өөр нэг хэлбэр юм. Тийм учраас хүчтэй, том гүрнүүдийг олж нөхөрлөх хэрэгтэй. Ийм эвслүүдийн жишээнд бүс нутгийн байгууллага болох АСЕАН, SAARC мөн түүнчлэн Номхон Далайн бүс дэх Өмнөд Номхон Далайн Чуулга байна. Энэ төрлийн байгууллагуудын давуу тал нь хууль ёсны дагуу баталгаажсан, хөрш орнууд тусгаар тогтнолыг нь хүлээн зөвшөөрсөн байх явдал жижиг орнуудын хувьд маш чухал. Бруней, Сингапур зэрэг жижиг орнууд өөрсдөдөө



тохирсон аюулгүй байдлаа хангах стратегитэй бөгөөд ер нь жижиг орнуудын дуу хоолой өсөн өргөжиж байна. Орчин үед хүч тэнцвэржсэн гэж цэргийнхэн хэлдэг. Хүчний тэнцвэрийн асуудал АСЕАН шиг нэр нөлөө сайтай, ач холбогдол, нөхцөл болзлын хувьд хүлээн зөвшөөрөгдсөн тийм байгууллагын гишүүн орнуудын хувьд байж болох юм. Дээрх үйл явц, байдал төлөв нь өнөөг хүртэлх Азийн санхүүгийн хямралыг үл харгалзан хэлж буй зөвхөн миний л үзэл бодол. Дээрхи маягийн харилцаанаас арай доогуур хэмжээний буюу үндэсний ашиг сонирхлын хувьд ялгаатай орнууд эвсэл холбоо байгуулбал түүний гишүүн орнуудын хооронд зөрчил мөргөлдөөн гарч мэдэх юм. Үүний нэг тодорхой жишээнд өнөөгийн Сингапур, Малайз хоорондын аль эсвэл Малайз, Сингапур, Индонезийн хоорондох харилцааны зөрчлүүдийг энд нэрлэж болох байна.

Улсын аюулгүй байдлыг хангах өөр нэг арга зам бол холбооны улсуудын хэлбэрт ойртох явдал юм. Ийм аргын цар хүрээтэй, дэг журамтай байгууламжийн хэлбэрүүдээс илэрхий томоохоноос нь нэрлэвэл Европын Холбоо, Хойт Атлантын Гэрээний байгууллага -НАТО, Ази, Номхон далайн Эдийн засгийн байгууллагууд юм. Дээрх байгууллагуудаас тэргүүлэх зэргийн ач холбогдолтой нь НҮБ байх нь мэдээж хэрэг.

Өнгөрсөн хугацаанд НҮБ-ыг үүсгэн байгуулагчдын санаж бодож хийхээр төлөвлөсөн зүйлсээс өнөөгийн НҮБ-ын удирдлага бараг юу ч хийсэнгүй. Үүнийг яаж тайлбарлах вэ? Нэг бол тэд хэзээ ч чадварлаг байгаагүй, аль эсвэл тэдэнд бие дааж юм хийх ямар ч боломж олгоогүй байж болох юм. Би үүнийг хүйтэн дайны үеийн саад тотгороос суурь үүдэлтэй болов уу гэж боддог. Харамсалтай нь одоо ч гэсэн хүйтэн дайны сүүдэр байсаар байна. Энэ чиглэлээр НҮБ онцгой үр дүнтэй үүрэг роль гүйцэтгэн ажиллаж чадна.

Сүүлийн үед НҮБ-д гарцаагүй хүчтэй тусламж дэмжлэг үзүүлэх ёстой том орнуудын тоо нэлээд буурч байна. Учир нь гэвэл зарим улс орнууд Хойт Атлантын Гэрээний байгууллага НАТО шиг тийм бүс нутгийн хүчирхэг байгууллагатай болж түүгээр Косовод болсон шиг тийм хурцадмал асуудлуудыг зохицуулах үүрэг хүлээлгэх хэрэгтэй гэж үздэг. Уг нь тэнд НАТО биш НҮБ илүү бодитой үйл ажиллагаа явуулах байсан гэж би үздэг. ОХУ-ын байр суурь тэнд илэрхий тодорхой харагдсан.

Одоо аюулгүй байдалд саад тотгор болсон зүйлээс хамгаалах ямар арга зам байж болох тухай өгүүлье.

Аюулгүй байдлыг хангах өөр нэг арга зам бол зарим хориг саадуудыг бий болгох талын юм байж болох байна. Бүрэн эрхт байдлаа аваад явж байгаа орны хувьд аюул учирвал түүний үнэ өртөг өсөн нэмэгдэж өөрийнх нь хүсээгүй зүйлийг ч хийлгэнэ. Үүний нэг тодорхой жишээ гэвэл Европт Швейцари, Израйль байна. Азид Ази, Номхон далайн бүсийн энэ маягийн стратегийн үнэнхүү уран барилгач нь Сингапур гэдгийг би хэлж чадах байна. Ийм маягийн стратегийн давуу тал гэвэл үндсэндээ хяналтыг өөрөө бие даан тавьж, бүхнийг өөрөө залж, чиглүүлж удирдана гэсэн үг.



Үүний муу тал буюу гарз хохиролтой тал гэвэл асар их өндөр үнэ өртөгтэй. Израйль АНУ-аас тусламжийн хэлбэрээр зэгсэн их хэмжээний тэтгэмж татаасыг энэ чиглэлээр чадварлаг авч чадаж байна. Энэ байдал нь Израйлыг хөршүүдээс нь холдуулахад хүргэж, тэдний дургүйцлийг төрүүлж байгаа тул Израйль тэдэнд асар их итгэл үнэмшил төрүүлж ятган сэнхрүүлэх хэрэгтэй болсон. Үүнд хийх шинжилгээний эцсийн дүн гэвэл Израйль ямар ч хөршгүйгээр ганцаарханаа оршдоггүйд байгаа юм. Израйль ч гэсэн үүнийгээ сайн ойлгож сургамж ч авсан.

Аюулгүй байдлаа хангах илүүтэй замуудын нэг бол идэвхитэй төвийг сахих зам, эсвэл эвсэлд үл нэгдэх бодлого барьж, хүчний тэнцвэр дэх үйл ажиллагаандаа орон бүхэнтэй хэлэлцэн тохиролцох ба хүч тэнцвэржүүлэх бодлого барих явдал юм. Энэ бол өртөг багатай зам, гэвч нөгөө талдаа тэр нь хэрээс хэтэрсэн их хяналт шалгалтыг өөртөө агуулдаг. Нөгөө талаар хүчнүүд нэг нэгэнтэйгээ байнга хуйвалдан тохиролцож, хэн нэгнээ ар хударгаар золигт гаргах наймаа хийж амждаг байна.

Ийм байдлын энгийн бодит жишээ гэвэл олон зуунаас эхтэй Польшийн хэрэг явдал юм. Мөн дэлхийн II дайны дараа Чехословакийн сэргээн босголтыг шууд яаралтай эхэлсэн зэргийг нэрлэж болох юм.

Эцсийн бүлэгт аюулгүй байдлаа хангах талаар сонголт хийхдээ туршилтын тоглолт хийж болох юм. Гэхдээ аль болох хялбар, ил гарч тоглох тоглоомыг сонгох нь чухал болов уу. Иймэрхүү тоглоомын давуу тал нь үнэ өртөг багатай. Үндэсний аюулгүй байдалд алсдаа тийм ч ноцтой аюул занал учрахгүй гэж үзвэл ингэж тоглож болох юм. Бирм Ни Вингийн үеэс 1962 он хүртэл иймэрхүү байдлаар явж ирсэн. Тэд SPCDC (Энх тайван, хөгжлийн зөвлөл) бий болох хүртэл, түүнээс хойш одоогийн АСЕАН-д нэгдэн ортлоо ингэж явсан юм. Гэвч илэн далангүй бодсон санасанаа илэрхийлэхэд Бирм маягийн стратеги нь өнөө үед тийм ч явууртай сонголт биш. Учир нь тухайн оронд чухал юмуу, чухал биш юмуу гэдгээс үл хамааран өнөөгийн дэлхий ертөнц глобалчлагдсаар байна. Глобалчилал нь өргөн уудам, дэлхий нийтийн гэсэн утгатай тэгээд ч ямар ч оронд дэлхий гэдэг "савнаасаа" хальж гарсан сондгой сонголт хийх зам байдаггүй.

Одоо би жижиг орнуудын хөгжлийн асуудал, тэдний хийж чадах өөр зүйлүүдийн тухай тогтож яриад сүүлчийн дүгнэлтээ хэлье.

Жижиг орнуудын эдийн засгийн хөгжлийн асуудалд танай орон ч хамрагдах нь мэдээж. Жижиг орнуудын эдийн засгийн өөрчлөлт, шилжилтийн үйл явц хүнд хэцүү зам туулдаг. Миний бодлоор жижиг орнуудын эдийн засгийг тодорхойлох зүйл нь багтаамж. Багтаамж багатай жижиг зах зээл эдийн засгийн өсөлтөд зарчмын чанартай үндсэн саад тогтор болдог. Энэ бол илэрхий тодорхой зүйл. Жижиг зах зээлтэй, бараа таваарын цар хүрээ явцуу, ҮНБ-д худалдааны эзлэх хувь хэмжээ их, худалдаанд түншүүдийнх нь юмуу аль эсвэл өргөн хэрэглээний зүйлсийн бөөгнөрөл давамгайлдаг. Жижиг орнуудын хүн ам тутамд ногдох ҮНБ-ий



хувь хэмжээ зарим тохиолдолд томоохон хөгжиж байгаа орнуудынхаас ч нэлээд өндөр байдаг. Жижиг орнуудын гадаад эдийн засгийн орчил нь бусад орнуудыг бодвол тийм ч их эмзэг биш. Эдийн засгийн энэ масштаб нь жижиг орнуудын хөгжлийн түлхүүр гэж би үздэг. Энэ нь орон нутгийн чанартай, жижиг эдийн засагтай нөхцөлд хэрэгжүүлэхэд хүнд хэцүү байж магадгүй, энэ нь ч амьдрал дээр тун тодорхой харагдаж байна. Жижиг орнууд бараа бүтээгдэхүүнийхээ борлуулалтандаа худалдааны шаардагдах хөнгөлөлтийг зохих хэмжээгээр эдэлдэг. Танай орон ч худалдааны ийм хөнгөлөлт эдэлж байгаа гэж бодож байна. Энэ нь стратегигийн болоод эдийн засгийн өсөлтийн замдаа сонголт хийхэд нь туслан дэмжиж байгаа хэрэг юм. Стратегийн нэг зайлшгүй чухал тал нь хөрөнгө оруулалтын санаачлагыг аль болох нэмэгдүүлэх, эдийн засгийн салбаруудад шаардагдах балансжсан хөрөнгө оруулалтыг олж авах явдал юм. Энэ нь жижиг орнуудын зах зээлийн багтаамж, өрийн асуудал зэргээс хамаарч хэрэгжих боломж төдий л магадлалтай бус. Балансжаагүй хөрөнгө оруулалт болоод түүнийг хэрхэн яаж ашигтай байлгах вэ гэдэг асуулт байнга зайлшгүй тавигдаж байдаг. Дээрх асуултанд хариу өгч болох нэг зам бол бүс нутагчлал. Жижиг орнууд бүс нутгийн хамтын ажиллагаанд аль болохоор нэгдэн орж ажиллаж чадвал зах зээлээ өргөтгөх боломж төдий чинээ нээгдэнэ. Дээрх бүх асуудлууд нь жижиг орнууд эдийн засгийн олон талт асуудлаа хэрхэн яаж амжилттай залж удирдахаас хамаарна. Энд эдийн засгийг либералчлах, нээлттэй байлгах асуудал маш чухал.

Төгсгөлд нь жижиг орнууд давуу талаа хэрхэн өсгөж болох тухай цөөн үг хэлье. Тухайн орны гол давуу тал гэвэл улсын аюулгүй байдал, дотоодын зах зээлээр тодорхойлогдоно. Дэлхийн технологи, худалдаа улам бүр чөлөөтэй, орон зайн хувьд давамгайлах байдалтай болж буй нь тухайн орны давуу талд тооцогдож байсан хүчин зүйлүүдийн тоо хэмжээг улам бүр бууруулж байна. Хэдэн сарын өмнө жижиг орны тухай нэгэн эдийн засагчийн бичсэн өгүүллийг та бүхэн олж үзсэн байхаа. Тэр өгүүлэлд сэргэн мандалтын үеийн Венец хотын тухай бичсэн байсан. 115 мянган хүн амтай энэ хот тэр үеийнхээ Хонг Конг байсан тухай өгүүлсэн нь түүхэн үнэнд ойртох чухал сануулга болсон юм. Глобалчлалын үйл явц нь жижиг орны сул тал, гарз хохирлыг улам бүр багасгана гэж би үздэг. Жижиг орон баян байх нь маш чухал. Орчин цаг үед бэл бэлчингээс их юм хамаарах боллоо. Бэл бэнчин маш чухал болохыг элчин сайд Ла Порта ч тэмдэглэн хэлж байсан. Хүн төрөлхтөнд хамгийн чухал үндсэн гол зүйл бол хөрөнгө бэл бэнчин. Энэ бол хөгжил дэвшил гэсэн үг. Бэл бэнчин, эд хөрөнгөнд хамаарах зүйлсийн нэг нь хүний үнэт зүйлс юм. Ер нь тухайн орны маш хүчтэй хуримтлал бол хүний үнэт зүйлс билээ. Ийм асар их үнэ цэнэтэй хуримтлалыг бий болгож чадсан жижиг орнуудад Швейцари, Австри, Норвеги, Швед орно.

Бүс нутгийн интеграци давамгайлж буй болон пүүсүүд хүчтэй интеграцчлагдаж буй нөхцөлд жижиг оронд бага зэрэг алдагдал гарз



хохирол учруулах байдлаар нөлөөлж болох юм. Хэдий тийм боловч энэхүү байдал төлөв нь жижиг эдийн засаг амжилттай хөгжих урьдач нөхцөл, цэвэр орчныг бүрдүүлж буй хэрэг юм.

Жижиг орон глобалчлалын өнөөгийн эриний эдийн засагт захирагдахын тулд өөрсдийн хэмжээнд бэлтгэлээ хангах, түүнд зохицон нэгдэх арга замаа олох хэрэгтэй.

Монгол улсад одоо энэ үйл явц ид өрнөж ажил үйлсээ энэ зүгт чиглүүлж байгаа гэж би үзэж байна

Энд улс орон дотооддоо хуулийн нилээд их аятайхан цэгцэрсэн цэвэр орчин, энгийн хялбар зохицуулалт бий болгож, албадлагыг багасгах хэрэгтэй.

Эдийн засагтаа тавьсан онцын шаардлагагүй хяналт хязгаарлалтуудаа устгах нь чухал. Энэ нь хэлэхэд үнэхээр хялбархан боловч төрийн хяналтын олон жилийн түүхтэй Монгол шиг олон орнуудад хэрэгжүүлэхэд амаргүй. Улс орнууд нийгэм хангамжийн сүлжээг бүрдүүлэх, түүний төрөл зүйлийг бий болгох нь нэлээд төвөгтэй. Ийм сүлжээ нь болзошгүй аюулын үед ард иргэдийг хамгаалах зайлшгүй нэг хэлбэр юм. Эдийн засгийн шинэчлэлийг бүрэн гүйцэд, алсын хараатай хэрэгжүүлэхэд дагалдах зайлшгүй зүйлийн нэг нь шилжилт хөдөлгөөн хийх, тандан судлах явдал маш чухал. Мөн түүнчлэн алив улс орон цэвэр худалдаан дээр суурилсан тийм үйл ажиллагаатай, өрсөлдөөнт санхүүгийн системтэй, тэр бүх хүрээг уялдуулан зохицуулсан удирдлагын хяналттай байх ёстой. Итгэл үнэмшил төрүүлэхүйц шийдвэрүүд нь сэдэв агуулгандаа бус улс орнуудын хувийн болон улс төрийн харилцаа холбоон дээр үндэслэн гардаг. Миний бодлоор бид бүгдээрээ олж мэдсэн нэг сургамж бий. Түүнд татагдан орсон орнуудын хувьд маш хатуу сургамж болсон юм. Энэ бол Азийн санхүүгийн хямрал. Тэрхүү хямралыг зарим орон тухайлбал Тайланд, Өмнөд Солонгос хоёр хоёулаа амжилттай гэтлэн давж хэвийн байдалдаа эргэж орлоо. Харамсалтай нь Индонез ингэж чадсангүй. Гэвч энэ нь капитализмын улиг болсон гэгддэг дутагдлыг илааршуулан цэвэршүүлэхэд зориулж улс орны гаргах өр төлөөс болон эдийн засгийн үнэт зүйлс ямар байхаас хамаарна. Миний бодлоор тэдгээр орнуудад сахилга хариуцлага туйлын муу, амин хувьдаа завших явдлыг хөхүүлэн дэмждэг. Ийм байдлыг эцэс болгохын тулд төрийн удирдлагын ашиг сонирхолтой хатуу тэмцэл явуулдаг, хөдөлмөрчдийн эрх ашгийг хохироодоггүй, тэдний эрэлт хүсэлт, шаардлагыг харгалзан үздэг иргэний нийгмийн систем байгуулах явдал юм. Энэ бүх зөвлөмжүүдийн дийлэнхийг нь аль эсвэл бүгдийг нь та бүхэн мэддэг, олж сонссон гэж би бодож байна. Энэ бол нийтийн мэдэх зөвлөмжүүд. Өөр нэг зүйлийг энд нэмж хэлэхэд хөгжингүй болон хөгжиж байгаа орнуудыг зарим талаар урхаг булингартай цэвэршээгүй хэсэг бүлгүүд сүүдэр мэт дагаж байдаг. Зарим талаар энэ нь хээл хахуулийн асуудал юм. Жишээ нь 1977 онд гадаадынхан Америкт хээл хахууль өгсөн гэсэн мэдээлэл гарсан.

Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага (OECD) 1977 оны арванхоёрдугаар сард хээл хахууль өгч авахын эсрэг олон улсын конвенци баталж гаргасан. Энэ конвенцид тодорхойлсон зорилтыг Монгол улс хүлээн зөвшөөрч түүнд нэгдэн орсон гэж би ойлгосон.

Англи хэлнээс орчуулсан Ц.БААТАР